



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

┌ Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн
батлах тухай ┐

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 38 дугаар тогтоол, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн оноосон нэр, хуулийн этгээдийн хэлбэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэгдсэн журмыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан менежер (Д.Ганзориг)-т даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан газрын даргын 2022 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР